



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2015 оны 03 дугаар сарын 11-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Сүлжээний тоног төхөөрөмж нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: SeljeeТТ-2015/01

Монголбанк нь эрх бүхий тендерт оролцогчоос ажлын хэрэгцээнд зориулан сүлжээний тоног төхөөрөмж нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Сүлжээний тоног төхөөрөмж нийлүүлэх тендер нь дараах багцтай байна.

Багц 1: Сүлжээний тоног төхөөрөмж /10 ширхэг/

Багц 2: Нууцлалын төхөөрөмж /1 ширхэг/

Тендерийн бичиг баримтыг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50,000.00** (тавин мянга) төгрөгөөр худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна:

Борлуулалтын хэмжээ: 160,000,000.00 / нэг зуун жаран сая/ төгрөг

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 160,000,000.00 / нэг зуун жаран сая/ төгрөг

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2013, 2014 он

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн 2 (хоёр) хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Гадаадын этгээд тендерт оролцохгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрнө. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны **4101000014** тоот дансанд тушаана.

Тендерийг 2015 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2015 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

### **МОНГОЛБАНК**

**Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, А байр 1 давхар,**

**Утас: (976) 11-322847, Факс: (976)-11-311471**